

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 8-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/176НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлангай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024 02-23 № 1-6/204

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН
8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З.ГАНТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 5-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын 5-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион

010000043

байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Ебаримт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 27 ширхэг 52 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 10.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Тайлант жилд 50,884.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.9 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийпээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,081,946.45	127,416,232.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,709,412.45	61,887,196.49
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,709,412.45	61,887,196.49
31210	Төгрөг	19,709,412.45	61,887,196.49
31211	Төрийн сангийн харилцах	15,442,612.45	53,535,396.49
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,266,800.00	8,351,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,372,534.00	65,529,036.00
35100	Түүхий эд материал	48,122,601.00	46,931,511.00
35110	Тусгай зориулалттай материал	48,104,501.00	46,900,001.00
35130	Эм боох материал	18,100.00	31,510.00
35400	Хангамжийн материал	12,249,933.00	18,597,525.00
35410	Бичиг хэргийн материал	522,400.00	358,300.00
35420	Аж ахуйн материал	6,583,277.00	11,103,235.00
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	30,000.00
35460	Хүнсний материал	5,014,256.00	7,105,990.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	716,407,265.18	679,304,125.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	716,407,265.18	679,304,125.86
39200	Биет хөрөнгө	688,164,548.72	651,406,809.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	731,182,677.17	731,182,677.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-93,550,779.10	-117,318,576.94
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	54,608,693.00	57,211,693.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,110,024.62	-35,523,669.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,689,652.35	57,689,652.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,741,028.34	-42,794,825.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,855,000.00	7,855,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,267,258.74	-7,392,758.82
39217	Ном	497,617.00	497,617.00
39300	Биет бус хөрөнгө	28,242,716.46	27,897,316.38
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-892,283.54	-1,237,683.62
39303	Бусад биет бус хөрөнгө	27,408,000.00	27,408,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	796,489,211.63	806,720,358.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	796,489,211.63	806,720,358.35
51	Засгийн газрын хувь оролцоо	796,489,211.63	806,720,358.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	272,831,525.00	272,831,525.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	272,831,525.00	272,831,525.00
51200	Хуримтлагдсан үр дүн	206,339,421.57	216,570,568.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-586,637,850.06	206,339,421.57
51220	Тайлант үеийн үр дүн	792,977,271.63	10,231,146.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	317,318,265.06	317,318,265.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	796,489,211.63	806,720,358.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,193,045,812.90	497,402,808.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	816,961,418.61	2,072,360.00
120	Нийтлэг татварын бус орлого	816,961,418.61	2,072,360.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	245,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	245,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	758,844,462.25	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	58,013,456.36	1,827,360.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,084,394.29	495,330,448.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,103,900.00	443,165,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,103,900.00	443,165,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	430,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	430,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,550,494.29	52,165,148.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,550,494.29	52,165,148.35
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	399,054,243.97	487,171,661.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,054,243.97	487,171,661.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,654,243.97	486,071,661.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,055,822.00	302,803,078.00
210101	Үндсэн цалин	178,671,634.00	244,767,561.00
210102	Нэмэгдэл	59,811,318.00	51,184,024.00
210104	Урамшуулал	5,572,870.00	6,851,493.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,443,974.55	38,834,337.96
210201	Тэтгэврийн даатгал	21,898,466.27	26,911,756.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,590,012.15	3,167,917.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,957,769.67	2,424,334.29
210204	Ажилгүйдлийн даатгал	454,338.61	575,484.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,543,387.85	5,754,844.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,960,484.29	42,265,148.35
210301	Гэрэл, цахилгаан	2,367,733.29	3,708,729.35
210302	Түлш, халаалт	29,057,875.00	32,245,939.00
210303	Цэвэр, бохир ус	5,534,876.00	6,310,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,386,053.00	9,259,142.00
210401	Бичиг хэрэг	750,900.00	884,700.00
210402	Тээвэр, шатахуун	140,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,298,744.00	4,694,082.00
210408	Бараа материал акталсны зардал	3,196,409.00	3,580,360.00
2105	Нормативт зардал	31,174,260.36	42,513,656.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,830.00	6,990.00
210502	Хоол, хүнс	31,100,430.36	42,506,666.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,434,850.00	2,890,860.00
210604	Урсгал засвар	2,434,850.00	2,890,860.00
2107	Томилолт, зочны зардал	144,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	144,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	615,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	615,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,514,799.77	46,890,439.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,131,700.00	4,571,300.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	960,200.00	2,613,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,422,899.77	39,706,139.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00	1,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	1,100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	793,991,568.93	10,231,146.72
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,014,297.30	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,014,297.30	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	792,977,271.63	10,231,146.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	382,074,834.29	500,760,448.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,235,300.00	5,430,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,235,300.00	5,430,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,235,300.00	245,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	568,500.00	245,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	4,666,800.00	0.00
120009	Бусад орлого	0.00	5,185,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,839,534.29	495,330,448.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,103,900.00	443,165,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,103,900.00	443,165,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,185,140.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,185,140.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,550,494.29	52,165,148.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,550,494.29	52,165,148.35
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	362,365,421.84	455,979,664.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,365,421.84	455,979,664.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,965,421.84	454,879,664.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,430,822.00	307,988,078.00
210101	Үндсэн цалин	195,870,774.00	217,696,053.01
210102	Нэмэгдэл	45,553,100.00	83,828,087.10
210104	Урамшуулал	5,006,948.00	6,463,937.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,443,974.55	38,834,337.96
210201	Тэтгэврийн даатгал	21,785,796.93	27,013,206.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,464,297.85	3,043,345.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,098.22	2,381,836.16
210204	Ажилгүйдлийн даатгал	477,052.70	581,413.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,768,728.85	5,814,536.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,960,484.29	42,265,148.35
210301	Гэрэл, цахилгаан	2,367,733.29	3,708,729.35
210302	Түлш, халаалт	29,057,875.00	32,245,939.00
210303	Цэвэр, бохир ус	5,534,876.00	6,310,480.00
2105	Нормативт зардал	33,398,491.00	44,598,400.00
210502	Хоол, хүнс	33,398,491.00	44,598,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,399,920.00	9,900,000.00
210604	Урсгал засвар	3,399,920.00	9,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	615,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	615,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,791,730.00	10,678,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,791,730.00	8,105,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,573,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00	1,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	1,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	1,100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,709,412.45	44,780,784.04
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,603,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,603,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,603,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2,603,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,603,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	19,709,412.45	42,177,784.04
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	19,709,412.45
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,709,412.45	61,887,196.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	272,831,525.00	393,318,458.58	229,220,068.55	895,370,052.13
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,831,525.00	393,318,458.58	229,220,068.55	895,370,052.13
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-76,000,193.52	-815,857,918.61	-
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	792,977,271.63	792,977,271.63
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,831,525.00	317,318,265.06	206,339,421.57	796,489,211.63
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	272,831,525.00	317,318,265.06	206,339,421.57	796,489,211.63
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,831,525.00	317,318,265.06	206,339,421.57	796,489,211.63
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,231,146.72	10,231,146.72
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	272,831,525.00	317,318,265.06	216,570,568.29	806,720,358.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,852,900.00	405,317,515.96	53,535,384.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,852,900.00	405,317,515.96	53,535,384.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,852,900.00	405,317,515.96	53,535,384.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,581,700.00	307,988,078.00	42,593,622.00
210101	Үндсэн цалин	237,610,100.00	217,696,053.01	19,914,046.99
210102	Нэмэгдэл	105,368,000.00	83,828,087.10	21,539,912.90
210104	Урамшуулал	7,603,600.00	6,463,937.89	1,139,662.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,222,600.00	38,834,337.96	5,388,262.04
210201	Тэтгэврийн даатгал	30,199,400.00	27,013,206.30	3,186,193.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,505,900.00	3,043,345.19	462,554.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,804,600.00	2,381,836.16	422,763.84
210204	Ажилгүйдлийн даатгал	701,200.00	581,413.67	119,786.33
210205	Эрүүл мэндийн даатгал	7,011,500.00	5,814,536.64	1,196,963.36
2105	Нормативт зардал	49,594,000.00	44,598,400.00	4,995,600.00
210502	Хоол, хүнс	49,594,000.00	44,598,400.00	4,995,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	857,700.00	615,000.00	242,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	857,700.00	615,000.00	242,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,596,900.00	13,281,700.00	315,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,023,900.00	10,708,700.00	315,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,573,000.00	2,573,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	458,852,900.00	443,410,300.00	15,442,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	443,165,300.00	443,165,300.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	443,165,300.00	443,165,300.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,687,600.00	245,000.00	15,442,600.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	245,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,442,600.00	0.00	15,442,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	15,442,612.45	-15,442,612.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	53,535,396.49	-53,535,396.49

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,059.1 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэнд аудитаас 6 зөвлөмж хүргүүлэн ажиллахаар шийдвэрлэлээ.

Аудитаар илэрсэн зөрчлийн 7,106,0 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитад хамаарч байх тул бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага гэж үзэн “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тавигдаагүй болно.

5.2 Албан шаардлага

Тайлант хугацаанд төлбөрийн акт тавигдаагүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр буюу өмнөх онтой харьцуулбал 42% иар нэмэгдүүлэн 7,106.0 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж 1: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

Энэ нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

Өгсөн зөвлөмж 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон бусад хууль, журам заавруудыг мөрдөж ажиллах

Илрүүлэлт 3: Үлдэх өртөггүй 51 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж, үнэ болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 3: Холбогдох хууль, журам заавруудыг мөрдөж ажиллах

Илрүүлэлт 4: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

Илрүүлэлт 4: Сайншанд сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байршуулах ёстой мэдээллийг тулган шалгахад Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 3,580.4 мянган төгрөгийн 4 тушаалыг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн

түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 4: А тушаал гарах тухай бүрд шилэн дансанд мэдээлж ажиллах

Илрүүлэлт 5: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 30 ширхэг 52 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 7,372.7 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 5: И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

Илрүүлэлт 6:Тайлант жилд 47,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь тус хуулийн 30.4-т заасан шууд гэрээ байгуулах нөхцөлийг бүрэн хангаагүй байна.30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах; 30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах

Өгсөн зөвлөмж 6: 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах
Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
байхгүй	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ДҮН										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс			
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр буюу өмнөх онтой харьцуулбал 42% иар нэмэгдүүлэн нөөцөлсөн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна.	1	7,106.0					1	7,106.0		
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.	1	-					1	-		

